

2023

жилийн тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ  
ҮНДЭСТЭНГ ЦОГЦЛООНО

Хүчтэй. Хамтдаа.

# Агуулга

Алсын хараа	4
Эрхэм зорилго	
Үнэт зүйлс	

▲ Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	5
---------------------------------	---

▲ Компанийн тухай	8
Түүхэн замнал	9
2023 оны онцлох үйл явдал	11
2023 оны онцлох тоон үзүүлэлт	13
Зээлийн үйл ажиллагаа	14
Санхүүгийн гол үзүүлэлт	15
Нийгмийн хариуцлага, Компанийн нийгэмд үзүүлсэн нөлөөлөл	17
Компанийн бүтэц	19
Хүний нөөц	20
Удирдлагын багийн танилцуулга	21

<b>▲ Бүтээгдэхүүн үйлчилгээ</b>	22
Ард Апп	23
Зээл	23
Кредит карт	24
АрдКидс	24
Pick n Pay	25
Сурсаке	25
Нийлүүлэлтийн гинжин хэлхээ	26
<b>▲ Компанийн засаглал</b>	27
Ногдол ашгийн мэдээлэл	28
Хувьцаа эзэмшигчдийн хурал	29
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	29
Хувьцааны арилжаа	30
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүд	31
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны шийдвэрлэсэн асуудлууд	32
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын чиг үүрэг	32
Эрсдэлийн үнэлгээ	35
<b>▲ Эдийн засгийн орчин</b>	37
<b>▲ Хараат бус аудитын тайлан</b>	41
Хамтрагч байгууллагууд	45

## **АЛСЫН ХАРАА**

Ирээдүйн ур чадвар, технологийг цаг хугацааны товчлолоор авчирч, тогтвортой хөгжлийг түргэтгэж, өндөр өгөөжийг бий болгоно.

---

## **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Салбарын хөгжлийг түүчээлнэ.

---

## **ҮНЭТ ЗҮЙЛС**

Хамтдаа хуваалцах

Тогтвортой хөгжих

Хүлээлтээс давж үйлчлэх

Хүртээмжтэй, тэгш оролцоог бүрдүүлэх

Ёс зүйтэй байх

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

*Эрхэм хүндэт Ард Кредит ББСБ ХК-ийн  
хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагсад,  
харилцагч танаа*

Гүйцэтгэх захирал

**Г.ТЭЛМЭН**



Бид 2023 оныг ололт амжилтаар дүүрэн, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж, бүтээлч түйвээлт хийсэн жил байлаа.

Нээлттэй ХК болсноос хойш хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг алдалгүй Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс, I ангилалд тасралтгүй багтсан амжилтаа хадгалж, нэгж хувьцааны ханш тогтвортой өсөлт үзүүлж 119.9 төгрөгөөр хаагдлаа. Мөн онд 2.0 тэрбум төгрөгийн 16.6 сая ширхэг хувьцаа арилжаалагдсан байна. Компани хувьцаа эзэмшигчдэдээ 2023 оны цэвэр ашгаас 1.0 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэлээ. Ингэснээр 5.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсний 98.1% буюу 5.2 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараажээ.

Компани 2023 онд 49.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болж, нийт хөрөнгөө 24.1% өсгөж 72.0 тэрбум, санхүүжилтээ 33.2% өсгөж 42.1 тэрбум, цэвэр ашгаа 22.3% өсгөж 2.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Бүтээлч түйвээлт гэж тодотгосны учир нь бид 2022 онд Монголбанкнаас карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авснаар энэ онд өөрийн систем дээр кредит карт гаргаж, хэрэглээнд нэвтрүүлээ. 2017 онд ББСБ-ын салбар анхны ко-бренд кредит карт гаргаж байсан бол энэ удаа мөн л салбартаа анхлан карт гаргагч ББСБ боллоо. Карт гаргагчийн тусгай зөвшөөрөл авснаар зөвхөн кредит картаас гадна дебит карт гаргах боломжтой болсон юм.

Мөн онд Монголбанкнаас Аутсорсингийн тусгай зөвшөөрөл авлаа. Ингэснээр Монголбанкнаас 3, Санхүүгийн Зохицуулах Хорооноос 5, нийт 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж, 1.0 сая гаруй харилцагчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэн ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагаанаас гадна компанийн гадаад харилцаа, мэдээллийн аюулгүй байдал, системийн найдвартай байдалд онцгой анхааран ажиллаж Чех улсын Праг хотод зохион байгуулагдсан Дэлхийн Бичил Санхүүгийн хуралд оролцож, Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Праг арга хэмжээг, Ардын Тэтгэврийн Данс

ХХК-тай хамтран БНСУ-ын санхүү хөрөнгө оруулалтын томоохон компаниудтай туршлага солилцож, Чех, БНСУ-д амьдран суугаа Монголчууддаа санхүү хөрөнгө оруулалтын мэдлэг түгээх зорилгоор Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Праг, Ирээдүйгээ Өмчил - Солонгос арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. 2022 оны 8 сараас эхлэн мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлсний үр дүнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүлж, гэрчилгээгээ хүлээн авлаа.

2023 оны 9 сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрлөө авсан бөгөөд энэ удаа компанийн 30% буюу 84 сая ширхэг хувьцааг нэмж гарган, нэгж хувьцаа 106 төгрөгөөр үнэлж, нийт 8.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх юм. Энэхүү тайлан танд хүрч буй үед бид 1,556 захилга авч, нэмэлт хувьцааны захиалгаа 102.2% амжилттай хаалаа. Ингэснээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэж итгэлцэл болон санхүүжилт татах орон зай, боломжууд нэмэгдэж компанийн хөгжилд томоохон түлхэц болох юм.

Ард Кредит 2024 онд бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам төгөлдөршүүлж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэдээ өндөр өгөөж хүртээж, нийт хөрөнгийг 110.9 тэрбум, Зээлийн багцыг 85.9 тэрбумд хүргэж 67.2 тэрбумын санхүүжилт татсанаар 6.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байна.

Компанийн түүхийн хуудсыг хамтдаа бичилцэж буй эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажиллагсдадаа талархал илэрхийлж, амьдрал, ажилд нь эрүүл энх сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Хүндэтгэсэн,  
Гүйцэтгэх захирал  
Г.Тэлмэн

# КОМПАНИЙН ТУХАЙ



# Түүхэн замнал

## 2011

- Интергрупп Интернэйшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдав.

## 2017

- Салбартаа анхлан Кредит картын үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв.

## 2018

- Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос IPO хийх зөвшөөрөл авч үнэт цаасаа бүртгүүлэв.
- Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх Ард Аппын анхны хувилбарыг олон нийтэд танилцуулав.

## 2019

- Хиймэл оюун ухаанд суурилсан цахим зээлийн үйлчилгээг Ард Аппаар дамжуулан олгож эхлэв.
- 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болов.
- Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаат компанийн I ангилалд дэвшин оров.

## 2020

- Монголбанкнаас Ард Кредит ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.
- EuroGiro олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Монгол Шуудан ХК-тай хамтран нэвтрүүлж, харилцагчдадаа дэлхийн 56 улсаас хамгийн бага шимтгэлтэй мөнгөн гуйвуулга хийх боломжийг нээв.
- АСН+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

## 2021

- Анхны виртуал хөрөнгө барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.
- Хүүхдэд зориулсан анхны санхүүгийн аппликейшн АрдКидс Аппыг зах зээлд нэвтрүүлэв

## 2022

- Pick n Pay /BNPL/ худалдан авалтын зээлийн үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлэв.
- Гүйлгээ бүрээс хуримтлал үүсгэх “CupCake - Хариултаа хадгал” хуримтлалын үйлчилгээг нэвтрүүлэв.
- 7 тэрбум төгрөгийн хаалттай бонд гаргах зөвшөөрөл авч, амжилттай татан төвлөрүүлэв.
- #БидИлүүБайжЧадна аяныг хэрэгжүүлж АрдКидс Аппад бүртгэлтэй 40,000 хүүхдийг эгнээндээ нэгтгэж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгов.
- 5 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг гаргах зөвшөөрөл авав.
- ББСБ-уудаас анх удаа карт гаргагчийн зөвшөөрөл авав

## 2023 оны онцлох үйл явдал



- ▲ Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс, I ангилалд 4 дэх жилдээ дараалан багтав.
- ▲ 7 тэрбум төгрөгийн хаалттай бондыг амжилттай эргэн төлөв.
- ▲ ICT EXPO 2023-д оролцов.
- ▲ Чех улсын Праг хотод зохион байгуулагдсан Дэлхийн Бичил Санхүүгийн Форумд оролцож, Праг хотод амьдран суугаа Монголчуудад санхүү хөрөнгө оруулалтын мэдлэг, мэдээлэл, боломжийг түгээх зорилгоор Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Праг арга хэмжээг зохион байгуулав.
- ▲ Зээлийн гэрээг Ард Аппаар баталгаажуулдаг болов.
- ▲ Хувьцаа эзэмшигчдэдээ хувь тэнцүүлэн, нийт 800 сая төгрөгийн АрдКойны урамшуулал олгов.



- ▲ Анхны карт гаргагчийн тусгай зөвшөөрөл бүхий Кредит картыг хэрэглээнд нэвтрүүлэв.
- ▲ Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан 2023 оны 2 дугаар улирлын Компанийн засаглалын кодексын үнэлгээний тайлангаар Хөрөнгийн биржийн I ангиллын ТОП-10 засаглал сайтай компанийн нэг болов.
- ▲ Ардын Тэтгэврийн Данс ХХК-тай хамтран БНСУ-д оршин суугаа Монголчуудад зориулан “Ирээдүйгээ Өмчил” арга хэмжээг 4 хотод зохион байгуулав.
- ▲ Санхүү эрхэлсэн захирлаар Д.Лхагва-Очир томилогдов.
- ▲ Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл авав.
- ▲ Монголбанкнаас Аутсорсингийн тусгай зөвшөөрөл авав.

## 2023 оны гол үзүүлэлтүүд

**13,700**

Хувьцаа эзэмшигч

**+410,000**

Зээлийн хүсэлт

**1,041,358**

Харилцагч

**75,988**

Олгосон зээлийн тоо

**52,515**

АрдКидс харилцагч

**₮72.0 тэрбум**

Нийт хөрөнгө

**₮49.6 тэрбум**

Зээлийн багц

**₮42.1 тэрбум**

Санхүүжилт

**₮104.2 тэрбум**

Олгосон зээлийн дүн

**₮24.2 тэрбум**

Итгэлцэл

**64,974**

Зээлдэгч /өссөн дүнгээр/

**₮2.5 тэрбум**

Цэвэр ашиг

## Зээлийн үйл ажиллагаа

### Зээлдэгч



### Нийт зээлийн багц (сая төгрөг)



### Зээл олголт (сая төгрөг)



### Зээл төлөлт (сая төгрөг)



### Хүү, шимтгэл (сая төгрөг)



### Зээлийн багцын чанар



Нийт үндсэн зээлийн эргэн төлөлт **94,698,094,988**  
Зээлийн жигнэсэн дундаж хүү **34.37%**

## Санхүүгийн гол үзүүлэлтүүд

### Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)



### Цэвэр зээл (тэрбум төгрөг)



### Санхүүжилт (тэрбум төгрөг)



### Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



### Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа



### Чанаргүй зээл



### Өрийн харьцаа



### Цэвэр ашиг (тэрбум төгрөг)





## Нийгмийн хариуцлага, Компанийн нийгэмд үзүүлсэн нөлөөлөл



Цахим үйлчилгээг иргэдэд үзүүлэн, цаасан гэрээг хэрэглээнээс халснаар нэг жилд 8,470 ширхэг мод, 23.1 тонн цаас, 1,542,857 квт эрчим хүчийг хэмнэж, нийт харилцагчдын цаг хугацааны хэмнэлт нь 74 жил буюу 648,240 цаг болсон байна.




Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгын хүрээнд **#БидИлүүБайжЧадна** аяныг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд аяны гол зорилго нь Монгол улсын бүх хүүхэд багачуудыг хөрөнгө оруулагч болгох юм. Ингэснээр хүүхэд бүр гэр бүлийн санхүүгийн чадамжаас үл хамааран тодорхой хэмжээнд хөрөнгө оруулагч болж, өөрийн нэр дээр хувьцаа болон ардквойныг эзэмших юм. Аяны хүрээнд Ардкйдс аппад бүртгүүлсэн хүүхэд бүрт Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа, ардквойныг бэлэглэж байна.



Энэхүү тайлан бэлтгэгдэж байх мөчид Монгол улсад хаваржилтийн хүндрэл бий болсон цаг үед 300 сая төгрөгийн үнэ бүхий уураг болон эрдсийн агууламж өндөр малын тэжээлийг хандивлахын зэрэгцээ Малчдын зээлдээ хөнгөлөлт үзүүлж, хүү болон үндсэн төлбөрийг 2024 оны 2 сарын 23-наас эхлэн 8 сарын хугацаатай хойшлуулж, мөн хугацаанд зээлийн хүүг зогсоож буйгаа зарлалаа.

## Компанийн бүтэц



## Хүний нөөц



Ард Кредит ББСБ ХК нь хүний нөөцийн бодлого тогтмол сайжруулан шинэчилж ирсэн бөгөөд нийт ажиллагсдын цагийн хуваарьт өөрчлөлт оруулан ажиллагсад уян хатан цагаар ажиллах болон зайнаас ажиллах боломжийг бүрэн бүрдүүлсэн бөгөөд тусгай хөгжилтэй болон бие давхар эмэгтэйчүүдийг ажлын байранд нээлттэй хүлээн авч ажиллуулах ажил хэргийг компанийн хүний нөөцийн бодлогодоо 100 хувь нийцүүлж чадлаа.

Үүний хажуугаар компанийн ажиллагсад компанидаа тогтвортой ажиллах, компанид ажиллаж байхдаа санхүүгийн хувьд бие даасан байх боломжийг хангах ажлуудыг тасралтгүй хийсээр байна. Тухайлбал ажилтан зөвхөн цалин, урамшуулал авахаас гадна хөрөнгө оруулалт хийх боломжийг ханган компанийн хувьцаа, виртуал хөрөнгийг дунд, урт хугацаанд эзэмшүүлж, ажилтан бүр хувийн тэтгэврийн хуримтлалтай болж, эрүүл мэнд гэнэтийн ослын даатгалын бүрэн хамруулах зэрэг ажилтны сэтгэл ханамжтай ажиллах боломжуудыг улам сайжруулан ажилласаар байна.

2023 оны Ард Кредит нийт 39 ажилтантай үйл ажиллагаа явуулсан. Үүний 63 хувийг эмэгтэйчүүд, 37 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд Удирдлагын түвшний ажиллагсдын 40 хувь нь эмэгтэй удирдлагууд байна. Ажиллагсдын дундаж нас 32.

▲ **Нийт ажилтан - 39**

▲ **Эрэгтэй ажилтан - 37%**

▲ **Дундаж нас - 32**

▲ **Эмэгтэй ажилтан - 63%**

## Удирдлагын багийн танилцуулга



**Г.Тэлмэн**

Гүйцэтгэх захирал



**Г.Сүхбаатар**

Бизнес хөгжил эрхэлсэн  
захирал



**Г.Чимэгсүрэн**

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
эрхэлсэн захирал



**Д.Лхагва-Очир**

Санхүү эрхэлсэн захирал



**А.Дуним**

Дижитал хөгжил эрхэлсэн  
захирал

# БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ




## Ард Апп

Ард Кредит ББСБ ХК нь Ард Аппаар дамжуулан харилцах данс, цахим мөнгө, төлбөр тооцоо, гүйлгээ, зээл, хуваан төлөх үйлчилгээ, итгэлцлийн үйлчилгээ үзүүлж байна.

- ▲ Бүх төрлийн төлбөр тооцоо, гүйлгээ
- ▲ Цахим зээл
- ▲ Урт болон богино хугацаат хуримтлалын үйлчилгээнүүд
- ▲ Онлайн дэлгүүр
- ▲ Үнэт цаас
- ▲ Даатгал

▲ Харилцагчийн тоо - **1,041,358**


▲ Итгэлцэл эзэмшигч - **4,094**



## Зээл

Бүх төрлийн зээлийн үйлчилгээг PHYCITAL (Physical + Digital) хэлбэрээр харилцагч нартаа хүргэн ажиллаж байна.

- ▲ Зээлийн багц - **49.6 тэрбум төгрөг**
- ▲ Олгосон зээлийн дүн - **₮104.2 тэрбум төгрөг**
- ▲ Зээлдэгчийн тоо /өссөн дүнгээр/ - **64,974**
- ▲ Зээлийн хүсэлт - **410,000**



## Кредит карт

ББСБ-ын салбарын анхны карт гаргагчийн тусгай зөвшөөрөл бүхий карт

▲ ЭЛИТ / ПРЕМИУМ



## АрдКидс

Хүүхдийн санхүүгийн хэрэглээг цогц хангасан Монголын анхны хүүхдэд зориулсан аппликейшн юм. 2022 онд АрдКидс Аппад Ирээдүйн Эзэн хүүхдийн хадгаламж, аав ээжээсээ утасны дугаараар дамжуулан АрдКойн хүлээн авах, гадаад улсад амьдарч буй хүүхдүүд утасны дугаараар дамжуулан бүртгүүлэх, найзаа урьж АрдКойн цуглуулах боломжийг нэвтрүүллээ. Мөн хүртээмжтэй байдал талаас аав ээж нь хүүхдээ утасны дугаараас гадна регистрийн дугаараар бүртгүүлэн урамшуулалт хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нээлээ.

▲ #БидИлүүБайжЧадна аяны хүрээнд Монгол улсын бүх хүүхдийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болгохоор ажиллаж байна.

▲ Харилцагчийн тоо - **52,515**

Ирээдүйн Эзэн хадгаламж эзэмшигчийн тоо - **2,096**


**KIDS**  
ARD

Stronger. Together.





## Pick n Pay



Төлбөр тооцооны цогц шийдэл бөгөөд төлбөр тооцоо, хуваан төлөх үйлчилгээ, урамшууллын оноо, интернет банкны шийдлийг нэг дороос авах боломжтой Харилцагч болон Байгууллагыг холбосон үйлчилгээ.

## Cupcake

6-24 сарын хугацаатай, гүйлгээ бүрээ тодорхой дүнгээр бүхэлчилж, БАГА ДҮНГЭЭР, ТОГТМОЛ ХУРИМТЛУУЛАХ хуримтлалын үйлчилгээ юм.

- ▲ Харилцагчийн тоо - **3,626**
- ▲ Хуримтлалын үлдэгдэл - **₮288.2 сая**





# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



---

## Ногдол ашгийн мэдээлэл

<b>2019</b>	<b>₮1.1</b> тэрбум
<b>2020</b>	<b>₮1.0</b> тэрбум
<b>2021</b>	<b>₮1.3</b> тэрбум
<b>2022*</b>	<b>₮0.8</b> тэрбум
<b>2023</b>	<b>₮1.0</b> тэрбум

\*хувь тэнцүүлсэн урамшуулал

## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Кредит ББСБ ХК нь хүний нөөцийн бодлого тогтмол сайжруулан шинэчилж ирсэн бөгөөд нийт ажиллагсдын цагийн хуваарьт өөрчлөлт оруулан ажиллагсад уян хатан цагаар ажиллах болон зайнаас ажиллах боломжийг бүрэн бүрдүүлсэн бөгөөд тусгай хөгжилтэй болон бие давхар эмэгтэйчүүдийг ажлын байранд нээлттэй хүлээн авч ажиллуулах ажил хэргийг компанийн хүний нөөцийн бодлогодоо 100% нийцүүлж чадлаа.

## Хувцаа эзэмшигчдийн бүтэц

▲ Ард Санхүүгийн Нэгдэл	<b>40.9%</b>
▲ С.Гэрэлтуяа	<b>9.8%</b>
▲ Ардын Тэтгэврийн Данс	<b>5.9%</b>
▲ Х.Батхишиг	<b>5.2%</b>
▲ С.Оргил	<b>4.2%</b>
▲ Г.Бат-Эрдэнэ	<b>4.2%</b>
▲ Ард Лизинг	<b>3.8%</b>
▲ Ард Бит	<b>2.6%</b>
▲ Н.Мөнхнасан	<b>2.5%</b>
▲ Эйч Ви Эл Эл	<b>2.5%</b>
▲ Олон нийт	<b>18.6%</b>

## Хувьцааны арилжаа



Хаалтын ханш ₮119.9

Дээд болон доод үнэ ₮98-138

Нийт эргэлтэнд байгаа  
хувьцааны тоо 280,000,000

Нийт арилжааны дүн ₮1.4 тэрбум

Зах зээлийн үнэлгээ ₮33.6 тэрбум

Арилжаалагдсан  
хувьцааны тоо 12.2 сая ширхэг

	2021	2022	2023
EPS(TTM)	₮14.0	₮7.4	₮9.0
P/E(TTM)	15.7x	17.5x	13.3x
P/B	2.7x	2.0x	1.6x

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд



**Ч.ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн дарга



**Г.ТЭЛМЭН**

Ердийн гишүүн



**Г.УЯНГА**

Ердийн гишүүн



**О.ОДБАЯР**

Ердийн гишүүн



**Б.ЗОЛБОО**

Ердийн гишүүн



**Б.ГАНБАТ**

Ердийн гишүүн



**В.ГАНЗОРИГ**

Хараат бус гишүүн



**Б.СОЛОНГО**

Хараат бус гишүүн



**С.ЭНХЧИМЭГ**

Хараат бус гишүүн

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны шийдвэрлэсэн асуудлууд

- ▲ ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэв
- ▲ Комплаенс хариуцсан ажилтныг томилов
- ▲ 2022 оны ТУЗ урамшуулал, 2023 оны төсөв батлав
- ▲ 2022 оны Гүйцэтгэх захирлын КРІ дүгнэн, батлав
- ▲ Ногдол ашиг тараахгүй шийдвэр гарсантай холбоотой нэгж хувьцаанд 0.1
- ▲ АрдКойныг хувь тэнцүүлэн урамшуулал олгох шийдвэр гаргав
- ▲ ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны цалин урамшууллыг батлав

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын чиг үүрэг

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэжлийн түвшинд удирдах зорилгоор Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, зээлийн хороодтой байх бөгөөд уг Хороод нь Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-өөр хэлэлцэх асуудалтай холбоотой зөвлөмж гарган ТУЗ-д танилцуулж ажилладаг.



## Дотоод аудитын хороо

Дотоод аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүд:

Б.Ганбат, Г.Уянга

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд:

В.Ганзориг, Б.Солонго, С.Энхчимэг

## Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гол зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын бодлогыг тодорхойлох асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр ТУЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахад оршдог.

### Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн: О.Одбаяр, Г.Уянга, Б.Ганбат


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн: В.Ганзориг, Б.Солонго

## Санхүү, эрсдэл, зээлийн хороо

Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь компанийн стратеги төлөвлөгөө, санхүү, зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлогыг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулахад хяналт тавьж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Хорооны гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн: О.Одбаяр, Б.Золбоо, Г.Тэлмэн



## Эрсдэлийн үнэлгээ

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая төгрөг/	2021	2022	2023	YoY
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,956	5,028	7,223	44%
Авлага	20,584	4,663	4,233	-9%
Хөрөнгө оруулалт	7,836	3,644	4,686	29%
Цэвэр зээл	34,178	40,038	47,942	20%
Нийт зээл	36,646	41,798	49,567	19%
Зээлийн эрсдэлийн сан	(2,468)	(1,760)	(1,625)	-8%
Бусад эргэлтийн хөрөнгө	2,021	2,597	3,558	37%
Эргэлтийн бус хөрөнгө	1,813	2,068	4,365	111%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>73,388</b>	<b>58,039</b>	<b>72,006</b>	<b>24%</b>
Өрийн бичгээрх өглөг	561	6,886	-	-100%
Итгэлцлийн өглөг	18,189	13,466	24,161	79%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	19,983	12,114	15,133	25%
Бусад өр төлбөр	11,178	7,415	11,702	58%
Хойшлогдсон татварын өр төлбөр	871	108	104	-4%
<b>Нийт өр төлбөр</b>	<b>50,782</b>	<b>39,989</b>	<b>51,101</b>	<b>28%</b>
Хувьцаат капиталын дүн	2,800	2,800	2,800	0%
Нэмж төлөгдсөн капитал	5,343	5,353	5,353	-
Хуримтлагдсан ашиг	7,409	8,298	10,837	31%
Хоёрдогч өглөг	-	5,000	5,000	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	7,053	(3,401)	(3,084)	-9%
Нийт эздийн өмч	22,605	18,049	20,905	16%
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>73,388</b>	<b>58,039</b>	<b>72,006</b>	<b>24%</b>

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Өссөн дүнгээр /сая төгрөг/	2021	2022	2023	YoY
Хүүгийн орлого	7,707	11,228	12,839	14%
Хүүгийн зардал	3,622	6,314	6,738	7%
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>4,085</b>	<b>4,914</b>	<b>6,101</b>	<b>24%</b>
Эрсдэлийн сангийн цэвэр зардал	1,998	1,841	2,572	40%
<b>Хүүгийн бус орлого</b>	<b>7,332</b>	<b>5,766</b>	<b>6,210</b>	<b>8%</b>
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	1,739	3,009	2,563	-15%
Арилжааны орлого	245	366	194	-47%
Тэнцлийн гадуурхаас орох	354	547	2,470	351%
Бусад орлого	4,994	1,844	983	-47%
<b>Хүүгийн бус зардал</b>	<b>4,905</b>	<b>5,902</b>	<b>6,294</b>	<b>7%</b>
Менежмент төлбөр	663	1,077	851	-21%
Автоматжуулалтын зардал	364	440	557	26%
Боловсон хүчний холбогдолтой зардал	1,269	1,739	2,124	22%
Маркетингийн зардал	1,015	879	1,042	19%
Бусад зардал	1,595	1,767	1,720	-3%
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн олз (гарз)	34	(503)	(494)	-2%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	4,548	2,435	2,951	21%
Орлогын албан татварын зардал	623	375	433	15%
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>3,925</b>	<b>2,059</b>	<b>2,519</b>	<b>22%</b>

## Эдийн засгийн орчин

Монгол улсын хувьд 2023 онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, уул уурхайн үйлдвэрлэл 23 хувиар өсөв. Үүнийг дагаад ачаа тээврийн орлого эрчимтэй нэмэгдсэнээс гадна өрхийн хэрэглээ үргэлжлэн сэргэж, худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварыг дэмжлээ. Улмаар эдийн засаг 2023 онд 7 хувиар өссөн нь сүүлийн 5 жилийн дээд үзүүлэлт боллоо.

Тодруулбал, энэхүү өсөлтийг -1.3 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 2.6 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.6 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.3 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.9 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.



## Инфляц

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 онд 13.2 хувь гарсан бол 2023 оны эцэст 7.9 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурч Төв банкны зорилтот түвшний дээд интервалд хүрч ирэв. Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 35.4%, мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 48.1% өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Сарын инфляц, %



## Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2023 оны эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 37.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.9 (26.8%) их наяд төгрөгөөр өсөхөд төгрөгийн харилцах 2.6 (40.5%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 4.5 (35.7%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн, 2023 онд Монголбанкнаас инфляцыг зорилтот түвшинд барихын тулд мөнгөний хатуу бодлогын хүүг өндөр түвшинд буюу 13.0%-д тогтвортой байлгав.


Банкны төгрөгийн зээлийн дундаж хүү 16.7%, долларын зээлийн дундаж хүү 10.5%-д хүрч, өмнөх оны мөн үеэс харгалзан 1.0%, 0.3%-иар нэмэгдсэн бол нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эцэст 27.4 их наяд төгрөг болж, өмнөх

оноос 5.1 (23.1%) их наяд төгрөгөөр өссөн байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 12.3 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөв. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж байна. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2023 оны 12 дугаар сард 38,553.9 нэгж болж өмнөх оноос 2,377.1 нэгжээр өссөн байна. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2023 оны 12 дугаар сард 11.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.7 (68.7%) их наяд төгрөгөөр өсжээ.

## Гадаад худалдаа, улсын төсөв


Монгол Улс 2023 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 15.2 тэрбум ам.доллар, импорт 9.3 тэрбум ам.доллар болж, тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 5.8 (31.3%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 23.2 их наяд төгрөгт хүрч, 6.1 (35.6%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 онд 22.5 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан түүхэн дээд үзүүлэлт болов.


Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /сая ам.доллар/



## Валютын ханш

Монголбанкны гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам долларт хүрч, өмнөх оноос 1.5 (45%) тэрбум ам.доллараар өсөв. Улмаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2023 оны 12 дугаар сард 3421.21 төгрөг болж, өмнөх оноос 10.08 төгрөгөөр чангарав.

Гадаад валютын албан нөөц





# **Хараат бус аудитын тайлан**



---



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Дэлэй тээр 9 даяар, ЮНЕСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
короо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

"Ард Кредит" ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Ард кредит ББСБ" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард кредит ББСБ" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн Аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

  
Б.О. ОРГАВАН  
УДИРДАХ ПАРТНЕР  
УЛААНБААТАР ХОТ  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2024 оны 3 дугаар сарын 28



## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,223,162	5,027,668
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,358,464	789,329
Харилцагчдад олгосон зээл	47,941,596	40,038,098
Бусад санхүүгийн хөрөнгө	3,327,068	2,855,132
Бусад эргэлтийн хөрөнгө	8,549,712	7,736,922
Үндсэн хөрөнгө	867,847	938,892
Биет бус хөрөнгө	2,737,697	652,707
<b>Нийт хөрөнгө</b>	<b>72,005,546</b>	<b>58,038,748</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	15,133,326	11,211,776
Өрийн бичгээрх өглөг	-	6,886,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	103,722	
Бусад эх үүсвэр	24,161,193	13,641,277
Бусад өр төлбөр	11,702,396	8,250,273
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>51,100,637</b>	<b>39,989,326</b>
<b>Эздийн өмч</b>		
Эзэмшигчдийн өмч	8,152,792	8,152,734
Бусад өмч	1,915,611	1,598,872
Хуримтлагдсан ашиг	10,836,506	8,297,816
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>20,904,909</b>	<b>18,049,422</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>72,005,546</b>	<b>58,038,748</b>



## Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	2023 он	2022 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	13,019,411	11,339,294
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(6,887,980)	(6,513,600)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>6,131,431</b>	<b>4,825,694</b>
Хүүгийн бус орлого	4,730,883	5,945,035
Хүүгийн бус зардал	(7,672,701)	(6,335,565)
<b>Цэвэр хүүгийн бус орлого</b>	<b>(2,941,818)</b>	<b>(390,530)</b>
Болзошгүй эрсдэлийн зардал	(2,840,634)	(2,530,969)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,639,593	575,759
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(37,201)	(45,389)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,951,371</b>	<b>2,434,565</b>
Орлогын татварын зардал	(432,710)	(375,341)
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,518,661</b>	<b>2,059,224</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	308,643	(10,365,666)
Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл	308,643	(10,365,666)
Хэрэгжсэн олз		-
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>2,827,304</b>	<b>(8,306,442)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>0.009</b>	<b>0.007</b>

## Хамтрагч байгууллагууд





+976 7700 3322



[info@ardcredit.com](mailto:info@ardcredit.com)



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Сүхбаатарын талбай-2 Сэнтрал Тауэр, 17 давхар